



**МОНГОЛ УЛСЫН  
ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМ**

17060 Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг,  
Чингисийн өргөн чөлөө, Засгийн газрын XIV байр,  
Утас: 51-263051, Факс: (976) 7004-3479  
E-mail: info@energy.gov.mn

2021. 03. 18 № 21944

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-г

**Хариу хүргүүлэх тухай**

Танай байгууллагаас ирүүлсэн орон нутгийн төсвийн хөрөнгөөр эрчим хүчний чиглэлээр хийгдэх барилга угсралтын ажлын тендерийг зарлахдаа ямар тусгай зөвшөөрлийг тендерийн баримт бичигт тусгах талаар зөвлөмж хүссэн албан бичигтэй танилцлаа.

“Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай” хуулийн 15.8.2-т эрчим хүчний эх үүсвэр, шугам сүлжээ барьж байгуулах, 15.8.5-т зуух, даралтат сав, шугам хоолойн угсралт, засвар үйлчилгээг эрхлэх тусгай зөвшөөрлийг тус хуулийн 7.1-т заасны дагуу Эрчим хүчний сайдын тушаалаар олгож байна.

Иймд эрчим хүчний чиглэлээр хийгдэх аливаа барилга угсралтын ажлын худалдан авах ажиллагааны тендерийн баримт бичигт Эрчим хүчний яамнаас олгож байгаа тусгай зөвшөөрлийг тусгаж байхыг зөвлөж байна.

ЭРЧИМ ХҮЧНИЙ БОДЛОГЫН  
ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИЦУУЛАХ  
ГАЗРЫН ДАРГА



Д.БАТЗОРИГ

170600970

072008074